

# **ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ**

## **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын санаачлан боловсруулсан Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл (цаашид “Хуулийн төсөл” гэх)-д Хууль тогтоомжийн тухай хуулийн 17 дугаар зүйлд заасны дагуу үр нөлөөний үнэлгээ хийв.

Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төслийн зохицуулалтын хэрэгцээ, үндэслэл, зорилгод нийцсэн эсэх, ойлгомжтой байдал, бусад хууль тогтоомжтой уялдаа холбоог тодорхойлох, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэх, хуулийн төслийн чанарыг сайжруулахад оршино.

Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан “шинэчилсэн найруулга” хэлбэрийн хуулийн төсөл бөгөөд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу дараах үе шаттайгаар үнэлгээ хийсэн. Үүнд:

- Шалгуур үзүүлэлтийг сонгох;
- Үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
- Шалгах хэрэгслийн дагуу үнэлгээ хийх;
- Үр дүнг нэгтгэн дүгнэх, зөвлөмж өгөх.

## **ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ**

Хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах харилцаанд үндэслэн дараах 3 шалгуур үзүүлэлтийг сонгож авлаа. Үүнд:

- Зорилгод хүрэх байдал
- Ойлгомжтой байдал
- Харилцан уялдаа

“Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд хуулийн төсөл нь Үндсэн хуульд заасан төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох зарчим, иргэний мэдээлэл авах эрхийг хангах шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлэх зорилготой.

“Ойлгомжтой байдал” шалгуур нь хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль болон хууль боловсруулах аргачлалын шаардлагыг хангаж, ойлгомжтой, хэрэгжих боломжтой эсэхийг шалгахад чиглэнэ.

“Харилцан уялдаа” шалгуур нь хуулийн төсөл нь Үндсэн хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль болон бусад холбогдох хуультай нийцэж байгаа эсэхийг тогтоох зорилготой.

## **ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ**

“Зорилгод хүрэх байдал” шалгуурын хүрээнд хуулийн төслийн үзэл баримтлал болон зохицуулалтыг харьцуулан судалж, ялангуяа дараах гол өөрчлөлтүүдэд үнэлгээ хийхээр сонгов. Үүнд:

- төрийн нууцын жагсаалтыг хуулиар батлах;
- албаны нууцын ойлголтыг халах;
- нууц тогтоох эрхийг хязгаарлах.

“Ойлгомжтой байдал” болон “Харилцан уялдаа” шалгуурын хүрээнд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэж үнэлгээ хийв.

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгах үүднээс хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

## **ДӨРӨВ. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар авч үзэв.

<b>Д/д</b>	<b>Шалгуур үзүүлэлт</b>	<b>Үр нөлөөг үнэлэх хэсэг</b>	<b>Тохирох шалгах хэрэгсэл</b>
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн 1 дүгээр зүйл	Зорилгод дүн шинжилгээ хийх
2	Ойлгомжтой байдал	Хуулийн төсөл бүхэлдээ	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалыг баримталсан эсэхийг шалгах байдлаар <u>ойлгомжтой</u> байдлыг шалгах.
3	Харилцан уялдаа	Хуулийн төсөл бүхэлдээ	Аргачлалын 4.10-т заасан стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог шалгах

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг дараахь байдлаар үнэллээ.

#### 1. “Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Монгол Улсын Үндсэн хуульд төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох зарчмыг тодорхойлсон байдаг. Гэвч одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжийн хүрээнд төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Засгийн газраар баталж, байгууллагын түвшинд нууц тогтоох боломж олгосон нь уг зарчимд нийцэхгүй байна.

Хуулийн төслөөр:

- төрийн нууцын жагсаалтыг зөвхөн УИХ батлах;
- хуулиас гадуур нууц тогтоохыг хориглох;
- “албаны нууц” ойлголтыг халах

зэрэг зохицуулалтыг тусгасан нь Үндсэн хуулийн шаардлагад нийцсэн, иргэний мэдээлэл авах эрхийг хангахад чиглэсэн байна.

Мөн төрийн нууцын хүрээг хэт өргөтгөсөн өнөөгийн нөхцөл байдлыг засах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, төрийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах бодлогын зорилготой нийцэж байна.

Иймд хуулийн төсөл нь зорилгодоо хүрэх боломжтой гэж үнэлэв.

#### 2. “Ойлгомжтой байдал” шалгуур үзүүлэлтийн үнэлгээ

Хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагын дагуу үнэлэхэд:

- Хуулийн зохицуулалт нь тодорхой, хоёрдмол утгагүй;
- Нэр томъёоны хэрэглээ нэгдмэл;
- Хэт ерөнхий ойлголтыг (албаны нууц) хассан;
- Зохицуулах харилцааг бүрэн хамарсан.

Мөн нууцын зэрэглэл, хугацаа, ил болгох нөхцөлийг тодорхой заасан нь хэрэгжилтийн ойлгомжтой байдлыг нэмэгдүүлсэн байна.

Энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг бүхэлд нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан хууль тогтоомжийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараахь асуултад хариулт өгөх замаар шалгалаа. Үүнд:

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага:

	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
1.	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх;	Шаардлага хангасан
2.	29.1.2.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Шаардлага хангасан
3.	29.1.3.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Шаардлага хангасан
4.	29.1.4.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан
5.	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Зөрчилгүй.
6.	29.1.6.хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Шаардлага хангасан
7.	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Шаардлага хангасан
8.	29.1.8.тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журам;	Шаардлага хангасан
9.	29.1.9.шаардлагатай тохиолдолд эрх зүйн хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын төрөл, хэмжээ, хуулийн хүчин	Шаардлагагтай.

	төгөлдөр болох хугацаа, хууль буцаан хэрэглэх тухай заалт, хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, бусад хуулийн зүйл, заалтыг хүчингүй болсонд тооцох, хасах заалт;	
10.	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх;	Шаардлагатай.
11.	29.1.11.хуулийн төсөл нь хуулийн зорилго гэсэн зүйлтэй байж болох бөгөөд зорилгод тус хуулиар хангахаар зорьж байгаа иргэний үндсэн эрх, бэхжүүлэх үндсэн зарчим, хүрэх үр дүнг тусгана.	Шаардлагагүй.

**Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага:**

№	Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Шаардлага хангасан эсэх
1.	30.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Шаардлага хангасан.
2.	30.1.2.нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Шаардлага хангасан.
3.	30.1.3.үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Шаардлага хангасан.
4.	30.1.4.хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Шаардлага хангасан
5.	30.1.5.жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Шаардлага хангасан

**“Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хийсэн үнэлгээ:**

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөө үнэлэх аргачлалд заасан дараах стандарт асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог бүхэлд нь шалгахыг зорилоо. Үүнд:

Д/д	Асуулт	Хариулт буюу дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа
2	хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх;	Шаардлага хангасан.
3	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх;	Нийцэж байгаа.
5	хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх;	Давхардсан зүйлгүй.
6	хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх;	Үгүй.
7	хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх;	Үгүй.
8	төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх;	Үгүй.
9	татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх;	Хуулийн төсөлд татвар, төлбөр хураамжийн асуудал тусгагдаагүй.
10	тухайн хуулийн төсөлд тусгасан тусгай зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалтыг Аж ахуйн үйл	Хуулийн төсөлд аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөлтэй

	ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд тусгасан эсэх;	холбоотой зохицуулалт тусгагдаагүй.
11	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх;	Үгүй.
12	хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх;	Хуулийн төсөл нь жендэрийн эрх тэгш байдлын асуудлыг хөндөөгүй.
13	хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
14	хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх;	Үгүй.
15	хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	Тусгасан.

### ТАВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох суурь зарчимд нийцүүлэн боловсруулагдсан бөгөөд төрийн нууцын эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, тогтвортой, хяналттай болгоход чиглэсэн байна. Ялангуяа төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Улсын Их Хурлаар батлуулах, хуулиас гадуур нууц тогтоох боломжийг хязгаарлах, “албаны нууц” гэх хэт өргөн хүрээтэй ойлголтыг халах зохицуулалт нь иргэний мэдээлэл авах эрхийг хангах, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

Хуулийн төсөл нь бодлогын баримт бичгүүд, тухайлбал “Алсын хараа-2050”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан ил тод, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэх зорилттой нийцэж байгаа бөгөөд төрийн нууцын хүрээг оновчтой тогтоосноор авлига, хүнд суртал, мэдээллийн хаалттай байдлаас үүдэлтэй сөрөг үр дагаврыг бууруулах боломжтой гэж үзэж байна.

Нийгэм, эдийн засгийн хувьд хуулийн төсөл батлагдсанаар төрийн нууцад үл хамаарах мэдээллийг нууцлах явдлыг хязгаарлаж, мэдээллийн ил тод, хүртээмжтэй

байдлыг нэмэгдүүлэх, төрд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны үр ашиг, хариуцлагыг дээшлүүлэх эерэг үр нөлөөтэй. Харин эрх зүйн хувьд хууль хоорондын зөрчил, давхардлыг арилгаж, нэр томьёо, зохицуулалтын нэгдмэл байдлыг хангах, хуулийн хэрэгжилтийг сайжруулах нөхцөлийг бүрдүүлнэ.

Гэвч хуулийн төслийг хэрэгжүүлэх явцад шилжилтийн үеийн зохицуулалтыг оновчтой тодорхойлох, төрийн нууцын шалгуур, ангиллыг илүү нарийвчлах, нууц мэдээлэл хамгаалах байгууллагын чадавхыг бэхжүүлэх, холбогдох бусад хууль тогтоомжтой уялдуулах ажлыг цогцоор нь хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Иймд тус хуулийн төсөл нь зорилгодоо нийцсэн, ойлгомжтой, харилцан уялдаатай, хэрэгжих боломжтой бөгөөд Монгол Улсад ил тод, хариуцлагатай, хүний эрхийг дээдэлсэн засаглалыг бэхжүүлэхэд эерэг үр нөлөө давамгайлах хуулийн төсөл гэж дүгнэж байна.

Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн төсөл нь зорилгодоо нийцсэн, ойлгомжтой, бусад хууль тогтоомжтой уялдсан, хэрэгжих боломжтой бөгөөд Монгол Улсад ил тод, хариуцлагатай засаглалыг бэхжүүлэхэд эерэг үр нөлөө үзүүлэхээр байна.